



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/33

Өмнөдэлгэр сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхэд, залуучуудын спорт цогцолбор барих ажлын зураг төсөв хийлгэх ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунгэрэл

Засаг даргын орлогч

Гишүүд: М.Сод-Ирээдүй

4-р багийн Засаг дарга

Ц.Оюун-Эрдэнэ

Биеийн тамирын арга зүйч

2.Ажлын явцад гүйцэтгэлийн хяналтыг сайтар тавьж, холбогдох хууль, журмын дагуу акт үйлдэн хүлээж авахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д даалгасугай.



ДАРГА

Л.БАЯРМАА

